

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-13</i>

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	3-13
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 11 дүгээр сарын 01-ний
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 8 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 41 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Батжаргал, С.Ганбаатар.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Х.Баярмаа, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер П.Чанцалдулам, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын ахлах аудитор Б.Мөнхцэцэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Р.Хангал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Дэд хорооны дарга Б.Пүрэвдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2024 оны Засгийн газрын урсгал зардлыг 93 тэрбум төгрөгөөр бууруулж, 2018 оноос хойш 6 болон 7 жилээр тэтгэврээ бодуулсан 58000 иргэний тэтгэврийн зөрүү 93 тэрбум төгрөгийн нөхөн олгох зардлыг 2024 оны улсын төсвөөс санхүүжүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргаж, уг саналтай

холбогдуулан Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж тайлбар хийв.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 4
Бүгд: 6
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 41 минут үргэлжилж, 8 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Б.ПҮРЭВДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
09 цаг 41 минут

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц олонх болсон тул Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1 дүгээрт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дахь хэлэлцүүлэг. Төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан гишүүний, Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно. Ирэх оны төсөвт тусгасан онцлог арга хэмжээг дурдвал,

Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхдэд олгодог тэтгэмж, нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж, байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхиээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох тэтгэмжийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 10 хувиар нэмэгдүүлэхэд төлөвлөж байна. Энэхүү арга хэмжээнд 217,7 мянган төрийн албан хаагч, 499,2 мянган тэтгэвэр авагч, давхардсан тоогоор нийт 146,9 мянган нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хүн хамрагдах болно.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг ирэх оноос хэрэгжүүлэхтэй холбогдуулан малчдын төлөх НДШ-ийн

50 хувийг, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа иргэний шимтгэлийг 100 хувь тус тус төрөөс хариуцах, нийт даатгуулагчдын тэтгэвэр тогтоолгоход баримтлах дараалсан 7 жилийг 5 жил болгож бууруулах, тэтгэврийн хуримтлалын нөөц санг мөнгөжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгаад байна.

Боловсролын шинэчлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагууд үнэ төлбөргүй хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцахад нь шаардагдах тэтгэлгийг ирэх оноос олгож эхэлнэ.

Ирэх онд хүүхэд хамгааллын төсвийг хүрэх үр дүн, гүйцэтгэлтэй нь уялдуулан 80 хувиар нэмэгдүүлж, 14,3 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөөд байна. Энэ нь хүүхдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг хангалттай бүрдүүлэхэд хүрэлцэхгүй хэдий ч салбар хоорондын уялдааг сайжруулах, орон нутгийн санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой хуваарилбал тодорхой үр дүн гарах боломжтой гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилсан “тэрбум мод”, “хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэн дэмжиж, хүнсний ногоо, газар тариалангийн ажлын явц, бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг технологийн парк, мах, ноос, арьс шир, түүхий эд, хүнс, сүү боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай арга хэмжээний төсөв болон ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, зээлийн хүүгийн татаасанд зориулж ирэх онд нийт 223,7 тэрбум төгрөг хуваарилна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн нийгэм эдийн засгийн үр ашиг, ач холбогдол бүхий төслүүдэд чиглүүлж, энэ хүрээнд төсвийн төсөлд нийтдээ 6,1 их наяд төгрөгийн хөрөнгийн зардлыг төлөвлөсөн нь ДНБ-ий 8,2 хувь, нэгдсэн төсвийн нийт зардлын 22,6 хувьтай тэнцэж байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,2 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 1050 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд төлөвлөөд байна.

Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Засгийн газрын ажлын хэсэг төсөв өргөн мэдүүлэхийн өмнө бүх аймгуудад ажиллаж, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдэд иргэдийн саналыг авах, иргэдээр эрэмбэлүүлэх ажлыг анх удаа зохион байгуулсан билээ. Үүний дагуу хот, хөдөөгийн хөгжлийг уртасгах, эрчим хүч, авто замын төслүүдэд зориулж ирэх онд 1,9 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 154 төсөл, арга хэмжээний 593,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгаад байна. Эдгээр төслүүдийг эхлүүлэх төдий бус харин хамгийн багадаа 1 жил хамгийн ихдээ 3 жилд багтаан хэрэгжүүлж, ашиглалтад оруулах зорилт тавьж, үүний дагуу 2024 онд хамгийн багадаа 30 хувийн санхүүжилтүүдийг тусгалаа.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих, тэргүүлэх ач холбогдолтой бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг гадаад зээл тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд эдгээрээс томоохон төслүүдийг дурдвал, Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл, Эрдэнэбүрэний УЦС-ын төсөл, Чойбалсан ДЦС-ын хүчин чадлыг өргөтгөх төсөл, Улаанбаатар хотын ундны ус хангамжийг сайжруулах болон төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл болон 10 аймагт дулаан станц барих төсөл зэрэг болно.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд туссан дээрх төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2,8 хувь болж, төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно.

Иймд ирэх оны төсвийн төсөлд тусгасан арга хэмжээтэй танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. Занданбат дарга чөлөө авсан байгаа. Чухал ажилтай учраас. Цэвэгсүрэн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор танилцуулна.

Ц.Наранчимэг: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээнд хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн болно.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа 2024 онд 40,7 хувьд хүрэх төлөвтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум ДНБ-ий 34,2 хувь, Нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум ДНБ-ий 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий хасах 2,8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна. Төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитаар дараах дүгнэлтийг өгсөн болно.

Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тооцоолоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, 1 маягийн болон жишиг магадлалтай 153 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Барилга байгууламжид зураг төсөлд магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах, эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Монгол Улсын төсвийн төсвийг УИХ-д өргөн барихдаа төсвийг боловсруулах, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх.

Төсвийн төлөвлөлтийн дунд болон урт хугацааны төлөвлөлтийг төсвийн алдагдлыг 2 хувиас бага байлгах.

Эдийн засгийн зохих харьцааг баримтлан төсвийн тогтвортой байдлын үндсэн зарчмыг хангаж, төсөвт үзүүлэх гадаад өрийн ачааллыг бууруулж төлөвлөлтийг сайжруулах.

Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх.

Улсын төсвөөс санхүүжилт хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх ажлыг зохион байгуулах, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах.

Гэрээний хэрэгжилтийг хангуулах.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх.

Улсын комисс хүлээж авах үйл ажиллагаанд субъектив сөрөг нөлөөлөлгүй байлгах тодорхой эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төсөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч хэрэгжилтэд нь хяналт тавих.

Төсвийн төслийг тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн хэсэг, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, удирдан зохион байгуулах.

Гадаад зээлийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хэлэлцээрт орж буй төсөл, арга хэмжээнд эдийн засгийн үр ашгийн тооцоог хийж, ач холбогдлоор нь эрэмбэлж санхүүжүүлэх журам, аргачлал боловсруулж, хуулийн хэрэгжилтийг хангах.

Хөгжлийн бодлогод нийцүүлэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг сайжруулахыг зөвлөж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Наранчимэг даргад баярлалаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Доржсүрэнгийн Занданбат Монгол Улсын Ерөнхий аудитор, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ядамын Самбууням Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ням-Осорын Уранцэцэг Сангийн яамны Төсвийн зарлагын ахлах шинжээч, Дангаасүрэнгийн Отгонжаргал Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Рэнцэндоржийн Хангал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Нямдаваагийн Сансармаа Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Пүрэвсүрэнгийн Чанцалдулам Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Баттогтохын Мөнхцэцэг Үндэсний аудитын газрын Аудитын

нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын ахлах аудитор.

Баярлалаа.

Хууль санаачлагчдаас асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Би 1 асуулт асуучихъя. Тэгэхээр 2016 оноос, 17 оноос IMF хөтөлбөр Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн байгаа. Тэгээд энэ хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэд хэдэн үүргийг Монгол Улсын Засгийн газар авсан. Тун удалгүй IMF-ээсээ, хөтөлбөрөөсөө гарсан. Гараад хэдхэн үүрэг Монгол Улсад үлдээд, бусдыг нь хөтөлбөрөөс гарсан учраас хүчингүй болгосон байгаа. Тэгээд энэ хүрээндээ цөөхөн үлдсэн зүйлийн 1 бол тэтгэврийг тогтоохдоо цаашидаа үргэлжлүүлэн 10 жилийн дунджаар тогтоох ийм үүрэг амлалт авсан. Энэ нь явж байгаад 7 жил дээр очоод зогссон байгаа. Тэгээд 5 жил байж байгаад 7 жил болсон. Тэгээд энэ 7 жил 2018 оноос хойш 6 болон 7 жилээр бодуулсан нийтдээ 58 мянган иргэн байгаа. Энэ хүмүүс төрийн тодорхой буруу бодлого шийдвэрээс болж нэг хэсэг хугацаанд 2018-2023 оны хооронд 5 жилийн хугацаанд нэг хэсэг хүмүүс хохирч үлдэх ёсгүй. Урд талынх нь болох дээр 5 жилээр бодуулсан, 23 оноос хойшоо болох дээр дандаа бас 5 жилээр бодуулна. Гэтэл энэ нэг хэсэг хүмүүс 5 жилээр, 7 жилээр, 6 жилээр бодуулсан, бодуулж хохирч үлдэх зурвас хугацаанд хохирч үлдэх ёсгүй гэж би үздэг.

Тийм учраас энэ хугацаанд 5 жилийн 2018-2023 оны хооронд тэтгэвэрт гарсан нийтдээ 58 мянган иргэний 93 тэрбум төгрөгийн нөхөн олговрын асуудлыг хууль өргөн барьж шийдвэрлүүлэх гэсэн боловч харамсалтай нь Нийгмийн даатгалын багц хууль хэлэлцэх явцад нөхөн бодохыг нь 5 жилээр бодож өгөхийг нь шийдвэрлэхэд, нөхөн олговрыг нь шийдэлгүй орхисон байгаа. Тэгээд энэ асуудал дээр энэ хүмүүсийн хохирлыг

төлөх талаар ямар бодлого шийдэл байгаа вэ гэдгийг Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяагаас асууя.

Х.Булгантуяа: *Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. 2023 оны 7 дугаар сард Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталсан. Ингэхэд 7 жилийн тэтгэвэр тогтооход тэтгэвэр тогтоолгогчийн өөрийнх нь сонгосон 7 жилээс тэтгэврийг боддог байсан бол үүнийг 5 жил болгож багасгасан. Үүнтэй холбоотойгоор хуульд нөхөн олговрын асуудал тусгагдаагүй. 24 оны 01 сарын 01-нээс өргөн барьсан төсвийн төсөлд 7 жилийг 5 жил болгохтой холбоотой тэтгэвэр, тэтгэвэр тэгэхээр түрүүний таны хэлсэнчлэн иргэдэд нэмэгдэж тооцогдохоор байгаа. Тэгээд үүнийг нэмэгдлийг төсвийн төсөлд тусгаад явж байгаа.*

Б.Пүрэвдорж: *Баярлалаа.*

Төсвийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Би үг хэлнэ. Тэгэхээр 2024 оны улсын төсвийн төсөлд нэг хийсэн дүн шинжилгээгээ танилцуулна. Ер нь энэ сүүлийн 4 жилийн хугацаанд бас хийсэн бас ажлынхаа тайланг бас тавих ёстой гэж үзэж байгаа.

Тэгэхээр аливаа улсын төсөвт зарлагын тусгай шалгуурууд байдаг. Түүний нэг нь экспендичер рульс буюу төсвийн зарлагын дүрэм байгаа. Тэгээд төсвийн зарлагад буюу Засгийн газрын гаргаж байгаа урсгал зардалд хязгаарлалт тавих зорилготой. Тэгэхээр энэ ер нь тодорхой хувьд барьдаг. Тухайн улсын эдийн засгийн өсөлт хэд байна, дээд тал нь түүгээр хязгаарладаг бас ийм хуульчилсан орнууд ч байж байдаг. Тэгэхээр энэ асуудлыг яаж шийдвэрлэж байна гэхээр манай төсвийн хүрээний мэдэгдлээр дунд хугацааны бодлогын баримт бичгээр энэ асуудлаа шийдвэрлэдэг байгаа. Гэтэл төсвийн

хүрээний мэдэгдлээ хэд хэд өөрчлөөд оруулж ирдэг ийм тохиолдол маш их байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зардал сүүлийн хэдэн жилд замбараагүй өссөн. 2020 онд 21 онд 4 жилийн өмнө 14 их наядын төсвийн зарлагатай байсан бол одоо 27,4 их наяд болж нэг дахин өсчихсөн байж байгаа. Тэгээд энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл энэ зардал өсөж байгаа үндсэн шалтгаан бол ерөөсөө зарлагаа эхэлж зураад байна. Зарлагаа ингэж гаргана гэж зарлагаа зурчхаад, тэрний дараа орлогоо зурдаг ийм зүйл сүүлийн хэдэн жилд хэрээс хэтрээд байна гэдгийг хэлье.

Монгол Улсын нийт зарлага ингээд нэг дахин өссөн энэ зүйлийг бас мөрийн хөтөлбөртэй бас харьцуулж хэлье гэж бодож байна. Монгол Ардын мөрийн хөтөлбөрт 2020 оны мөрийн хөтөлбөрт нэг дахин иргэдийн орлогыг 1 дахин, 2 дахин нэмэгдүүлнэ ээ ингэж заасан. Гэтэл иргэдийн амьдрал огт өсөөгүй. Харин дарга нарын зарцуулдаг зардал 2 дахин нэмэгдсэн. Ийм үзүүлэлт гарч байна.

Хөрөнгийн зардлын хэмжээ 6,2 их наяд болсон. Тэгээд энэ нь 6,2 их наядын 3,2 их наяд нь төсвийн хөрөнгө оруулалт байгаа. 3 их наяд нь орон нутаг болон яамнууд руу өгч байгаа бас төсвийн зардлууд байж байдаг. Тэгээд энэ хөрөнгийн зардлууд чинь бүгдээрээ тэр чигээрээ гадагшаа валютын урсгал болж гарч явах ийм нөхцөл байдал руу орж байгаа.

Дээрээс нь 2021 онд 11 их наядын урсгал зардалтай байсан бол 2024 онд 21,3 их наядын урсгал зардалтай болж байгаа. 10 их наядар нэмэгдсэн байж байна. Тэгээд энэ чинь манай Монгол Улс чинь үйлдвэрлэгч орон биш хэрэглэгч орон. Тийм учраас бүх бараа бүтээгдэхүүнээ бүгдийг нь гаднаас авдаг ийм орны хувьд энэ төсвийн тэр их урсгал зардлууд бүгдээрээ валют болоод

гадагшаа урсдаг. Үүнээсээ болоод олон муу үр дүнгүүд гарч байгаа. Тэгээд энэ төсвийн хөрөнгө оруулалт дээр өнгөрсөн жилийн хувьд нийтдээ 315 төсөл, хөтөлбөрийг царцаах юм бол 500 орчим тэрбум төгрөгийг хэмнэх ийм боломжтой байна гэж өнгөрсөн жилийн Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дээр мэдэгдэж байсан. Тэгэхээр энэ жилийн хувьд нийтдээ 241 төсөл, арга хэмжээ үүнийг царцаах юм бол 927 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргах ийм боломж байна. Тэгэхээр 241 төсөл, арга хэмжээг би огт хэрэггүй гэж байгаа юм биш. Яг өнөөдрийн бас энэ ирээдүйдээ хуримтлал үүсгэх ийм шаардлагатай энэ үед тодорхой хэмжээгээр энэ хөрөнгө оруулалтуудыг хойшлуулах ийм боломжтой хөрөнгө оруулалт гэж үзэж байгаа. Тэгээд тэлсэн төсвийн уршиг маш их өндөр байдаг. Яагаад гэвэл маш их тийм хөрөнгө гадагшаа валют болж урсах учраас инфляц үүсэх, валютын хани нэмэгдэх ийм эрсдэл рүү дагуулж байгаа.

Дээрээс нь дэлхийн зах зээл дээр одоо бол яах вэ, нүүрсний болон уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр бас нэлээн өндөр байгаа. Гэтэл энэ үнэ уначих юм бол хэт их тэлсэн тэр төсвийн зардлаа бид нар яаж дараа нь нөхөх вэ гэдэг. Тэрэнд сурчихсан тэр урсгал зардлаа бид нар яаж бууруулах вэ гэдэг нь бас том эрсдэл болж хувирна л гэж үзэж байгаа.

Мөнгөний бодлогод тэлсэн төсвийн уршиг бол мөнгөний бодлогууд шууд нөлөөлдөг. Мөнгөний нийлүүлэлт 11,6 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа. Дөрөвхөн жилийн дотор. Үүнээс шалтгаалаад валютын хани 23 хувиар өссөн. 3450 дээр оччихсон байж байна. Энэ бүгдээрээ инфляцад шууд нөлөөлөх гол зүйл болчихоод байгаа.

Төсвийн алдагдал замбараагүй их үйлдвэрлэж байна. Тэгээд 2020 онд 4,4 их наяд, 2021 онд 3 их наяд, 2022 онд 1 их наядын юутай гарлаа гэж. Өөрөөр

хэлбэл алдагдалтай гарлаа гэж баярлаад байгаа. Гэтэл энэ дээр Ирээдүйн өв сангийн 1,4 их наядыг тэг болгож байгаад хэрэглэчихсэн байж байгаа. 2023 онд 1,4 их наядын алдагдалтай төсөв баталлаа гэсэн. Гэвч дахиад л Ирээдүй өв сангийн 1,4 их наядыг бас тэглэж байгаад хэрэглэчихсэн. Тэгж байгаад алдагдлаа бууруулсан. Тэгээд 2024 онд 2 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв оруулж ирж байгаа. Тэгээд энэ 20-24 оны хооронд 15 их наяд төгрөгийн төсвийн алдагдал үйлдвэрлэсэн байна. Тэгээд өнөөдрийн эрх баригч нар 10 их наяд төгрөгийн янз бүрийн өр төлчихлөө гэж яриад байгаа. Энэ 2016-2020 оны хооронд бий болгосон төсвийн алдагдал 10 их наяд төгрөгөө л төлсөн хэрэг. Бусдаар өөр тийм төлбөр төлөөд яваад байсан юм огт байхгүй ээ гэдгийг хэлье.

Сангийн яамны өргөн барьсан төсөл дээр Засгийн газрын өрийг жил болгон бууруулаад явж байгаа. Тэгээд өнөө энэ жилийн хувьд ирэх жилийн хувьд 42,7 хувьтай болгож байна гэж мэдэгдээд байгаа юм. Тэгээд энэ дээр ер нь Засгийн газрын дунд хугацааны стратегийг чанд сахисны үр дүнд өрийн дарамт буурч байна гэж мэдэгдсэн байгаа. Энэ дээр тодорхой заль байгаа. Тэмүүлэн дарга та энд харж байгаа бол. Өөрөөр хэлбэл ДНБ-ээ 75 их наяд болгочоод тэгээд өрнийхөө хэмжээг багасгачхаж байгаа байхгүй юу даа. Үгүй ээ, тэгвэл дотоод ДНБ-ээ 100 их наяд болгочоод бүр өрөө багасгах хэрэгтэй шүү дээ. Бүр 20 хэд рүү оруулаад бид нар ёстой гайхалтай чадвартай ажиллаж байна гээд л. 80 сая тонн нүүрс гаргана гэж тавьчхаад л түүнийгээ хамгийн өндөр үнэтэйгээр тавьчхаад л тэгээд энэ эдийн засгаа ДНБ-ээ томруулчхаад л буцаагаад л тэр өрнийхөө хувийг ДНБ-д багасгаад яваад байж болно шүү дээ. Ийм маягаар эдийн засаг хэд тэлж байна гэж нэг тийм пропаганд үүсгээд тэрнээсээ 42,7 хувь болгож, Засгийн газрынхаа өрийг багасгаж байна гэж худлаа ярьдгаа бас манай Засгийн газар болих ёстой гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн илтгэл дээр манай Монголын Засгийн газрын өр 76,2 хувь байгаа гэж байгаа. Энэ байгууллага чинь Монгол руу орж ирж байгаа тэр Свифт одоо сүлжээгээр бүх нөгөө валютын урсгалыг бүгдийг нь хянаж байгаа. 5000 долларыг хүртэл хянаж байгаа. Гэтэл энэ байгууллага чинь бүх Свифт сүлжээгээрээ дамжуулаад Монгол руу хэд орсон юм, хэд гарсан юм. Тэр бүх зүйлийг тооцож үзэж байгаад дотоодын нийт бүтээгдэхүүнийг нь бодитоор үнэлж байгаад танай өр чинь 76,2 хувь байна. Энэ бол хөгжиж байгаа орнуудаас 28 хувиар илүү байна гээд ингээд зарлаад байна шүү дээ. Тэгээд энэ үүний гол асуудал нь түрүүний би хэлээд байна шүү. Өөрөөр хэлбэл ДНБ-ээ 75 их наяд болгочоод л, 75 их наяд болсон учраас манай Засгийн газрын өр 42,7 хувь дээрээ байна гэж заагаад байгаа юм л даа. Гол асуудал эндээ байгаа.

2020 оны 6 сарын 30-ны байдлаар 26 их наяд төгрөгийн, Засгийн газрын нийт өр 26 их наяд байсан. Гэтэл ирэх онд 36 их наядын өртөөгөөр 10 их наяд төгрөгийн Засгийн газрын өрийг ингээд л үйлдвэрлээд явж байгаа. Тэгээд би түрүүн хэлсэн. Өөрөөр хэлбэл бид нар уул уурхайгаас орж ирж байгаа орлогоо аль болох зардлаа багасгаж байгаад тэгээд Ирээдүйн өв сандаа хуримтлуулах замаар ирээдүйдээ бид нар хэрэглэх ёстой юм. Өнөөдөр 7 жилийн туршид МАН-ын Засгийн газар 1 юман дээр, нэг сайхан зүйл дээр сууж байгаа. Тэр байнгын уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт бий болгосон энэ он жилүүд дээр сууж байгаа. Тийм учраас азтай байгаа. Бусдаар 2012-16 оны үе шиг нүүрс 25 доллароор зардаг байсан үеийнх шиг байх юм бол энэ өнөөдрийн ийм зардалтай ийм Засгийн газар Монгол Улсыг дампууруулчихсан байж байгаа л гэдгийг хэлмээр байна.

Тэгэхээр энэ Монгол, ер нь гадаад өрийн хэмжээ нэмэгдэхээр гардаг асуудлуудыг хэлье л дээ. Инфляц дандаа

өндөр хувьтай байна, 2 оронтой тооноос буухгүй. Ажилгүйдлийн түвшин дандаа өсөж байна. Тийм учраас Монгол залуучууд гадагшаа бүгд ажил хийхээр Монголоос зугтаж байна. Хадгаламж буурч байгаа. Өөрөөр хэлбэл, иргэдийн орлого, төсөв нь данхайгаад, төсөв рүү хамаг татвараар орлогыг нь татаад явчихаар тэгээд түүнд нь үрэлгэн зардлыг бий болгоод байхаар хүмүүс өөрсдийнхөө хадгаламжаас үрж эхэлж байна, эхэлнэ. Тэгээд төсөв мөнгөний бодлогод сөргөөр нөлөөлнө. Валютын хани байнга өснө. Хэтэрхий их төсвийн тэлэлт явагдахад мөнгөний бодлого чангарна. Мөнгөний бодлого чангарахаар яах вэ? Зээл олгохоо болино. Зээл олгохоо болихоор ААН-үүд хөрөнгийн дутагдлаас болоод дампуурах ийм нөхцөл байдал руу орж байгаа юм.

Тийм учраас энэ хэтэрхий их төсвийн тэлэлтийн энэ бодлогоо чангаруулах, ялангуяа уул уурхайгаас орж байгаа орлогоо тодорхой хувиар ирээдүйдээ авч үлдэх, аливаа хуримтлалыг бий болгох тэр зүйлийг хийх ёстой. Гэвч харамсалтай нь энэ 2024 оны төсөв дээр хувийн хэвшилээ дэмжих ямарваа нэгэн зүйл байхгүй байна. Ер нь би энэ Туркийн жишигээг хэлэх дуртай. Яагаад гэвэл өнөөдөр Турк бол Европын бүх бараа бүтээгдэхүүнийг жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангадаг ийм орон болсон. Энэ орон болох үндсэн суурь нь юу вэ гэхээр жижиг дунд үйлдвэрлэлийг бий болгоод, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн нь аливаа татварын системээр ороод борлуулагдаж байгаа тэр ААН-ийн банкнаас авсан зээлийг төсвөөсөө хүүг нь төлөх замаар зээлийн хүүг нь төлөх замаар дэмжиж явсан. Тийм ч учраас жижиг дунд үйлдвэрлэл Турк улсад асар их хөгжсөн. Өнөөдөр дэлхийн улс орнууд яаж байна гэхээр төсвөөрөө дамжуулж хувийн хэвшилээ илүү сайн дэмжсэн тэр улс орнууд л хамгийн сайн хөгжиж байгаа. Гэтэл энэ төсвийн бодлого чинь ерөөсөө энэ хувийн хэвшилээ дэмжих талаар ерөөсөө 1

ширхэг ч тийм хөтөлбөр зорилт алга байна.

2024 оны Их Хурлын гишүүн дахиж сонгогдох тойрог, тойрогтоо жалгын нэг хөрөнгө оруулалтыг тавьсан ийм төсөв болсон байна гэж хэлмээр байна. Тэгээд энэ асуудал дээр төсвийн хэлэлцүүлгийн явцад Төсвийн байнгын хороо болон Их Хурал бас энэ дээр тодорхой арга хэмжээ авна гэж итгэж байна. Баярлалаа.

1 зүйлийг бас бичлэгтээ оруулчихна. Сая Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан миний хэлсэн илтгэлд эгдүүцээд гараад явчихлаа шүү.

Төсвийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Янз янзын, бүр ёстой дураараа, дураараа л байна. Ер нь хуульд оруулах бүх заалтыг. Төсвийн хууль, Нийгмийн даатгалын хууль, ЭМД-ын 24 оны төсвийн хуулиуд, тэгээд дагах хуулиуд дээр бүгд дээр нь гаргаж болно.

Би зарчмын зөрөөтэй санал гаргана. 2018 оноос хойш 6 болон 7 жилээр тэтгэврээ бодуулсан 58 мянган иргэний тэтгэврийн зөрөө 93 тэрбум төгрөгийн нөхөн олгох зардлыг 2024 оны улсын төсвөөс санхүүжүүлэх. Одоохон. Би нөгөө бууруулах зардлаа. Засгийн газрын урсгал зардлаас зардлыг. 2024 оны Засгийн газрын урсгал зардлыг 93 тэрбум төгрөгөөр бууруулах.

Гаргасан саналтай холбогдуулан гишүүд санал байна уу? Би тайлбараа хэлчихсэн, түрүүн.

Сангийн яамнаас тайлбар хийе гэж байна. Тайлбар хийчих.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж саяын энэ зарчмын зөрөөтэй санал дээр тайлбар хийх гэсэн юм. Тухайн үед валютын санд орж

байгаатай холбоотойгоор дараалсан 5 жилээс тооцож байгаа тэтгэврийг 7 жил болгохыг үе шаттайгаар нэмэгдүүлэхийг тухайн үед хууль оруулж баталж байсан. Шинээр баталсан Нийгмийн даатгалын багц хуулиар буцаад 5 жилээр дараалсан 5 жилээс тэтгэврийг тооцож олгохыг хуульчилж байгаа. Үүнтэй холбоотойгоор хууль мөрдөгдөж эхэлсэн хугацаанаас тухайн 7 жилээр тогтоолгосон хүмүүсийг 5 жилээр нь шинэчлэн тогтоогоод, тэр шинэ тэтгэврийнх нь дагуу тэтгэврээ аваад явчих юм.

Тэгэхээр яах вэ, одоо нөгөө өнгөрсөн хугацааны нөхөн олговрын асуудал орж ирж байна. Хууль болохоор нөгөө Нийгмийн даатгалын багц хууль маань урагшаагаа нөхөж үйлчлэх боломжгүй учраас бид түүн дээр нөхөн олговор тавихад бас зөрчлийн асуудал үүсэх юм байна. Түүн дээр хэрвээ тавьсан тохиолдолд, нөхөн олговор тавьсан тохиолдолд бид нар өгч чадахгүй байх нөхцөл үүсэх юм байна гэдгийг л тайлбар тодруулъя л гэсэн юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр нөгөө Нийгмийн даатгалын багц хууль тэгээд Нийгмийн даатгалын багц хуулийг өөрчлөх шаардлагагүй. Яагаад гэвэл төсвийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, ерөнхий хууль бүгдээрээ органик хуулиуд. Өөрөөр хэлбэл энэ төсвийн 2024 оны Нийгмийн даатгалын төсвийн тухай, 2024 оны төсвийн тухай хууль 2-т өөрчлөлттэй энэ асуудлыг тусгасан тохиолдолд Засгийн газар энэ асуудлыг шийдвэрлээд явах үүрэгтэй болно гэдгийг хэлье.

Ингээд зарчмын зөрөөтэй саналыг дэмжсэе гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

2 хүн дэмжсэнээр, 4 хүн эсэргүүцсэнээр уналаа.

Байнгын хороонд санал, дүгнэлтийг Пүрэвдорж уншина.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

10.22 цаг

Зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ